

**МОНГОЛ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН
АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ: ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

(Тойм судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэ,
И.Жаргалзаяабямба, Р.Нургүл, Ц.Ариунаа*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ойлголт ба эрх зүйн орчин

- 1.1.Түүхэн тойм
- 1.2.Олон улсын чиг хандлага, хамтын ажиллагаа
- 1.3.Эрх зүйн орчин
- 1.4.Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын тогтолцоо, бүрэн эрх
- 1.5.Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээ

Хоёр.Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, дотоод бүсчлэл, тэдгээрийн хамгаалалтын дэглэм

- 2.1.Дархан цаазат газар
- 2.2.Байгалийн цогцолборт газар
- 2.3.Байгалийн нөөц газар
- 2.4.Дурсгалт газар
- 2.5.Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс
- 2.6.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах

Гурав. Тулгамдсан асуудал

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНГ	Байгалийн нөөц газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХОУХ	Байгаль хамгаалах олон улсын холбоо
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ДГ	Дурсгалт газар
ДЦГ	Дархан цаазат газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
УИХ	Улсын Их Хурал
УТХГНХЗ	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
ЮНЕСКО	НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1: ДЦГ-ууд
 Хүснэгт 2: ДЦГ дахь малчин өрхийн судалгаа
 Хүснэгт 3: БЦГ-ууд
 Хүснэгт 4: БЦГ дахь малчин өрхийн судалгаа
 Хүснэгт 5: БНГ-ууд
 Хүснэгт 6: БНГ дахь малчин өрхийн судалгаа
 Хүснэгт 7: ДГ-ууд
 Хүснэгт 8: ДГ-уудын малчин өрхийн судалгаа
 Хүснэгт 9: ТХГН дахь газар ашиглалтын судалгаа

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1: Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ
 Зураг 2: Дархан цаазат газрын дотоод бүс
 Зураг 3: БЦГ-ын дотоод бүс

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт, хамгаалалт: эрх зүйн орчин, өнөөгийн байдал, зарим тулгамдсан асуудал” сэдэвт тойм судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин ба өнөөгийн нөхцөл байдал болон тулгамдсан асуудлын талаар тоймлон судлах.

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, үндэсний сүлжээ, ангилал, бүсчлэл, тэдгээрийн хамгаалалтын дэглэм болон удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, чиг үүрэг, тусгай хамгаалалттай газар эрхлэх үйл ажиллагаа, газар ашиглах нөхцөл, журмын талаарх асуудлыг хууль, эрх зүйн орчны хүрээнд тоймлон судалсан болно. Мөн тусгай хамгаалалттай газар нутгийн тухай шинжлэх ухааны холбогдох ном, товхимол, судалгаа, шинжилгээний материалуудын хүрээнд судалсан. Судалгаанд Байгаль хамгаалах олон улсын холбоо (БХОУХ, International Union for Conservation of Nature-IUCN)²⁹² болон түүний Дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгуудын хороо (ДТХГНХ, World Commission on Protected Areas-WCPA)²⁹³-оос гаргасан судалгаа, дүн шинжилгээний тайлан, холбогдох олон улсын гэрээ конвенцын мэдээлэл, хууль, эрх зүйн баримт бичгүүд, бусад мэдээллийн эх сурвалжуудыг ашиглав.

Судалгааны бүтэц: Судалгаа нь Хураангуй болон үндсэн 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ойлголт, түүхэн тойм, ач холбогдол, олон улсын чиг хандлага, үндэсний удирдлагын тогтолцоо, сүлжээний асуудлын талаар, Хоёрдугаар хэсэгт, Монгол Улс дахь тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, дотоод бүсчлэл, тэдгээрийн хамгаалалтын дэглэм, орчны бүс болон тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах нөхцөл, журам болон өнөөгийн нөхцөл байдлын талаар, Гуравдугаар хэсэгт, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: Тусгай хамгаалалттай газар нутаг, Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар

Key words: Protected Areas, Strictly Protected Area, Wilderness Area, National Park, Natural Reserve, Natural Monument

²⁹² <https://www.iucn.org>

²⁹³ <https://www.iucn.org/our-union/commissions/world-commission-protected-areas>

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Байгаль орчныг хамгаалах олон янзын чиг хандлага, арга хэрэгсэл байдгаас олон улсад түгээмэл хэрэглэгддэг хамгааллын дээд хэлбэр нь газар нутгийг “улсын тусгай хамгаалалтад авах” явдал юм.

Монголчууд олон мянганы турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдарч ирсний хувьд байгалийн онцгой тогтоц, ховор амьтан, ургамлаа онголон тахиж, дархлан хамгаалж ирсэн өнө эртний уламжлалтай агаад энэ нь зөвхөн шүтлэг бишрэл, зан үйлийн хэмжээнд төдийгүй аман болон бичмэл хууль цаазад тусгагдаж бодитой мөрдөгдөж иржээ.

1778 онд дархалсан Богдхан уул дэлхийд анхны дархан цаазтай газар юм. Монгол Улс 1950-иад оны үеэс газар нутгийг тусгай хамгаалалтад авах дэс дараатай арга хэмжээ авч эхэлсэн байдаг. 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1997 оны Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол Улсын хуулиуд, мөн УИХ-ын 1998 оны “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” батлах тухай 29 дүгээр тогтоол, Засгийн газрын 1995 оны “Дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын нийтлэг болон тусгай горим” батлах тухай 169 дүгээр тогтоол зэрэг эрх зүйн актууд тус тус батлагдан гарснаар тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх өнөөгийн эрх зүйн орчин үндсэндээ бүрэлдэн тогтжээ.

Монгол Улс олон улсын байгаль хамгаалах чиглэлийн 16, үүнээс тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх 6 гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан ба тусгай хамгаалалттай газар нутгийн олон улсын ангилал, арга зүй, стандартыг өөрийн хууль тогтоомждоо тусган мөрдүүлж байна. Түүнчлэн энэ чиглэлээр олон улсын байгууллага, гадаад улс орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж, тусгай хамгаалалттай газар нутгуудад хамгаалалтын чадавхыг бэхжүүлэх, менежментийг сайжруулахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх олон янзын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг нь улсын тусгай хэрэгцээний газрын нэг хэлбэр юм. Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлд улсын тусгай хэрэгцээний газрын эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат, байгалийн цогцолборт, байгалийн нөөц, дурсгалт газар гэж ангилдаг.

Монгол Улс 2030 онд гэхэд нийт газар нутгийнхаа 30 хувийг тусгай хамгаалалтад авах зорилт дэвшүүлсэн. Өнөөгийн байдлаар Монгол орны газар нутгийн 21 хувь буюу 32.8 сая га талбай бүхий 120 газар нутгийг

улсын тусгай хамгаалалтад аваад байна. Үүнээс: дархан цаазат газар 22, байгалийн цогцолборт газар 37, байгалийн нөөц газар 47, дурсгалт газар 14 байна.

Хамгаалалтын менежментийн хувьд, эдгээрээс Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа 34 хамгаалалтын захиргааны мэдэлд 22 дархан цаазат газар, 34 байгалийн цогцолборт газар, 6 байгалийн нөөц газар, 2 дурсгалт газар байх бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр хамгаалалтын менежментийг гүйцэтгэж байна. Мөн түүнчлэн төр- хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 2 байгалийн цогцолборт газрын хамгаалалтын менежментийг ТББ хариуцаж, бусад тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг орон нутгийн байгууллагууд хариуцан гүйцэтгэдэг байна.

Тусгай хамгаалалттай газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан дотоод бүсүүдэд хуваадаг. Эдгээр дотоод бүсчлэл нь бүс тус бүрдээ мөрдөх хязгаарлалтын нөхцөл, тусгайлсан журам болон хамгаалалтын дэглэмээр тодорхойлогдоно. Тухайлбал, дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын онцгой бүс, аялал жуулчлалын бүсэд уламжлалт мал аж ахуй эрхлэхийг хориглодог.

Дархан цаазат болон байгалийн цогцолборт газар дахь сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний ахуй амьдралыг баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ. Орчны бүс нь дархан цаазат газрын хилийн заагт байх бөгөөд байгалийн цогцолбор газрын хувьд энэ нь хилийн заагийн гадна, эсхүл хязгаарлалтын бүстэй давхацсан байж болно. Орчны бүсэд орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог хангах зорилго бүхий орон тооны бус орчны бүсийн зөвлөлийг ажиллуулдаг.

Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалтаар, тодорхой хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр хуульд заасан зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн гэрээгээр ашиглуулж болохоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан байна. Энэхүү зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгодог. Газар ашиглуулах гэрээний хугацаа 5 жилээс доошгүй байх бөгөөд хугацааг 1 удаа 5-аас доошгүй жилээр сунгаж болно. 2023 оны байдлаар 17 хамгаалалтын захиргааны харьяалах нутаг дэвсгэрт 2 940 иргэн, аж ахуйн нэгжид 5 861 га газар ашиглуулах зөвшөөрөл олгогджээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүс болон орчны бүсийн хамгаалалтын менежментийн үйл ажиллагаанд уугуул малчин өрхийн аж ахуйн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх, уян хатан зохицуулах асуудал тулгамддаг. Байгаль хамгаалах хүчин чармайлтыг орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан хослуулах нь тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн урт хугацааны өгөөж, үр нөлөөг хангах чухал арга хэрэгсэл, тогтвортой, хүртээмжтэй менежментийн хандлага гэж олон улсын байгууллага, судлаачдын зүгээс үздэг байна.

БОАЖЯ-наас ирүүлсэн тоо баримтаас харахад 22 дархан цаазат газарт нийт 710 малчин өрх уламжлалт мал аж ахуй эрхэлж, тэдгээрийн 460 мянга гаруй тоо толгой мал, 585 өвөлжөө, 247 хаваржаа, 34 намаржаа, 317 зуслан байршиж байгаа бол 37 байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрт 9 731 малчин өрх, тэдгээрийн 3.0 сая гаруй тоо толгой мал сүрэг, мөн 4 671 өвөлжөө, 3 504 хаваржаа, 1 370 намаржаа тус тус байршиж байна. *(Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралтаас үзнэ үү)*

Мөн түүнчлэн нэн ялангуяа тухайн газар нутгийг тусгай хамгаалалтад авахаас өмнө тэнд оршин амьдарч байсан уугуул малчин өрхүүдийн мал сүрэг, бэлчээр, өвөлжөө, хаваржааны асуудал ихээхэн маргаан дагуулдаг. Энэ нь нэг талаас малчид өвөлжөө, хаваржааныхаа газрыг тодорхой хугацаагаар эзэмших зөвшөөрлийг өмнө нь нэгэнт авсан, зөвшөөрөл нь хүчинтэй хэвээр байдаг тул Үндсэн хууль болон газрын тухай хуульд зааснаар газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авсан тохиолдолд тухайн газар нутгийг эзэмшигч иргэнд улсаас нөхөн олговор олгох ёстой байдаг. Гэтэл энэхүү нөхөн олговрыг улсын төсөвт тусгаж шийдвэрлэдэггүй зэргээс үүдэн маргаантай асуудал үүссээр байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

**НЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ
БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Тусгай хамгаалалттай газар нутаг гэдэг нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон амьтан, ургамал бүхий газар нутаг, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрийг улсын тусгай хэрэгцээнд авч, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах, тодорхой зорилгоор ашиглах үйл ажиллагаа юм.²⁹⁴

Хүрээлэн буй байгаль орчиндоо дасан зохицож байж тогтвортой хөгжинө хэмээх үзэл баримтлал сүүлийн үед дэлхийн улс орнуудын түгээмэл чиг хандлага, хөгжлийн зорилт, үндсэн чиглэл болоод байна.

Байгаль орчныг хамгаалах олон арга хандлага, арга хэрэгсэл байдгаас олон улсын хэмжээнд түгээмэл хэрэглэдэг нь газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах явдал юм. Газар нутгийг тусгай хамгаалалтад авахын давуу тал нь амьтан, ургамлыг амьдрах орчинтой нь хамт экосистемийн хувьд иж бүрнээр нь хамгаалж, биологийн олон янз байдал, амин орон (biosphere)-ы тэнцвэр алдагдахаас сэргийлж, амьдрах аятай таатай орчин бүрдүүлж байдаг. Газар нутгийг эдэлбэр, ашиглалтад орж унаган төрх нь алдагдахаас өмнө хамгаалалтад авах нь нэгэнт эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээхээс хамаагүй бага зардал шаарддагаараа онцлогтой юм.

1.1.Түүхэн тойм

Монголчууд олон мянган жилийн турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж, байгаль орчиндоо дасан зохицож амьдарч ирсний хувьд байгалийн үзэсгэлэнт газар, ховор амьтан, ургамлаа дархлан хамгаалж, онголон тахиж ирсэн өнө эртний уламжлалтай.²⁹⁵

Монголчууд эрт үеэс байгаль хамгаалах харилцааг зан заншил, шашин шүтлэгийн хэм хэмжээ төдийгүй хууль тогтоомжоор зохицуулж иржээ. XII-XIII зууны үед Ван хан Тоорил Богд уулыг дархлан тахиж Хан уул хэмээн нэрлэж байсан, Чингисийн “Их засаг” хуульд байгаль хамгаалах заалтууд байсан хэмээх дам ишлэл байдаг боловч шууд бичмэл хэлбэрээр уламжлагдан ирсэн баримт нотолгоо үгүй юм. Харин 1294 онд гаргасан Монголын Их Юань улсын хууль цаазын 398 дугаар бүлэгт “Богд хан уул, Отгонтэнгэр, Хан Хэнтий, Алтайн нүсэр даваа” зэрэг байгалийн

²⁹⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=479>

²⁹⁵ Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Д.Мягмарсүрэн, УБ 2000 он, 3 дахь тал

үзэсгэлэнт газруудыг дархан цаазтай болгож байжээ. Мөн Ойрдын “Цааз бичиг”, “Халх журам” зэрэг Монголын эртний хууль цаазуудад байгаль хамгаалах, байгаль орчинтой зүй зохистой харилцах талаар нарийн тусгасан байдаг. Жишээлбэл, “Халх журам” хуульд Богд хан уул, Хан хэнтий, Хөгнө хаан, Жаргалант хан, Баян, Суман, Улаан, Төвхөн хан, зэрэг 14 байгалийн үзэсгэлэнт ууланд ан агнах, газар хөндөх, мод огтлохыг цаазлан хориглосон байна. Манж дайчин гүрний Тэнгэрийг тэтгэсний 44 дүгээр он буюу 1778 онд Богд хан уулыг албан ёсоор дархалж, 1809 оноос эхлэн 28 амыг цагдаатай болгож нутаг дэвсгэрт орох зөвшөөрлийг Богд хаан гардан олгодог хүртэл журам тогтоож байжээ. 1818 онд Отгон тэнгэр, Булган уулыг дархлан хамгаалсан түүхтэй байна.

1911 онд Богдхаант Монгол улсыг зарлан тунхагласны дараа Богд уулыг “Богд хайрхан уул” гэж нэрлэн, уулыг хамгаалах захиргаа байгуулж байжээ.²⁹⁶

Монголчуудын энэхүү түүхэн уламжлалыг судалсан Оросын эрдэмтэн И.Д.Лаптаев: “Монголчууд байгальтай харьцах талаар Европчуудаас олон зуун жилээр түрүүлсэн байлаа...” хэмээн бичсэн байдаг.²⁹⁷

Үүнээс хойш 1950-иад оны үеэс газар нутгийг тусгай хамгаалалтад авах дэс дараатай арга хэмжээ авч эхэлсэн. Тухайлбал, 1954 онд Батхаан уул, Нагалхаан уул, 1965 онд Уран тогоо-тулга-жалавч уул, Булган уул, Ёлын ам, Лхачинвандад уул зэрэг газруудыг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар дархан цаазтай болгосон байна. Мөн 1975 онд говийн байгаль, ховор амьтдыг хамгаалах зорилгоор Говийн их дархан газар, 1977 онд Хөх сэхийн нурууг тус тус дархалжээ. БНМАУ-ын СнЗ-өөс “БНМАУ-ын дархан газрын дүрэм”-ийг 1975 онд баталсан байна.

1991 онд Засгийн газраас “Тусгай хамгаалалттай газрын дүрэм” батлан, тусгай хамгаалалтын горим, дэглэмийг тодорхойлж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангилалд оруулсан нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх эхлэл болсон юм.

1992 онд Бразил Улсын Рио-Де-Жанеро хотод болсон НҮБ, Дэлхийн байгаль хамгаалах сангаас санаачлан зохион байгуулсан олон улсын бага хуралд манай улсыг дэлхийн шим мандлын онцгой бүс нутаг болгох тухай саналыг дэвшүүлсэн бөгөөд энэ хуралд Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат тавьсан илтгэлдээ улс орныхоо нийт нутаг дэвсгэрийн 30% буюу 46.9 сая га газрыг тусгай хамгаалалтад авахаа илэрхийлж дэлхий нийтэд зарласан байдаг.

²⁹⁶ Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Д.Мягмарсүрэн, Д.Энэбиш (Ph.D), УБ 2007 он, 4-5 дахь тал

²⁹⁷ Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Д.Мягмарсүрэн, УБ 2000 он, 16 дахь тал

1994 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1997 онд Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол улсын хуулиуд шинээр гарч улмаар 1995 онд дархан цаазат газар (ДЦГ), байгалийн цогцолборт газар (ЦБГ)-ын нийтлэг болон тусгай горимыг Засгийн газар, 1998 онд “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийг УИХ батлан гаргаж мөрдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх өнөөгийн эрх зүйн үндэс үндсэндээ бүрдэн тогтжээ.

1.2. Олон улсын чиг хандлага, хамтын ажиллагаа

Газар нутгийг тусгай хамгаалалтад авах нь зөвхөн тухайн орны төдийгүй бүс нутаг, дэлхий дахины байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хангахад тодорхой хувь нэмэр оруулдаг. Энэ нь экологийн амин чухал үйл явцыг дэмжих байгалийн бүс бүслүүрийн иж бүрдлийг төлөөлсөн ховордсон ан амьтан, ургамал, мөн байгаль, соёлын дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх өндөр ач холбогдолтой юм.

Улс орон бүр тусгай хамгаалалттай газар нутгийг онцлог, ач холбогдлоор нь ангилж, түүндээ тохирсон бүртгэл, зохицуулалт, хяналтын системийг бүрдүүлэн олон улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээний байгууллагуудад бүртгүүлж байдаг.

Өнөөгийн байдлаар дэлхийн 130 гаруй улсад Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бүрэлдэн тогтсон бөгөөд дэлхийн газрын гадаргын 5 орчим хувийг тусгай хамгаалалтад аваад байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь дэлхийн улс орон бүрд харилцан адилгүй дүрэм журамтай байдаг ба тэрхүү ялгаа, онцлог нь тухайн улс орны хууль эрх зүйн орчин, эдийн засгийн хүчин чадал, санхүүгийн дэмжлэг зэргээс шалтгаалдаг.

БХОУХ (IUCN)²⁹⁸-оос Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, тэдгээрт зөвшөөрөгдөх үйл ажиллагааны талаар нэгдсэн журам гаргасан. Үүнд: Тусгай хамгаалалттай газар нутгийг үндсэн 7 (6) категорид хуваасан байдаг.²⁹⁹ Тэдгээр нь:

1. **Strictly Protected Area (IUCN, Ia).** Дархан цаазат газар: Байгалийн унаган хэв шинж, биологийн олон янз байдлыг тэр хэвээр нь хадгалан хамгаалах зорилготой, хүний бүх төрлийн үйл ажиллагааг хориглох бөгөөд зөвхөн шинжлэх ухааны зорилгоор байгалийн унаган байдалд нөлөөлөхгүйгээр ажиглалт, судалгаа хийх боломжтой;

²⁹⁸ <https://www.iucn.org>

²⁹⁹ Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Б.Оюунгэрэл, УБ 2004 он, 11 дэх тал

2. **Wilderness Area (IUCN Ib).** Онгон байгаль: Энэ газар нутагт байгалийн унаган төрхийг хамгаалж, зөвхөн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр амралт, зугаалгын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг;
3. **National park (IUCN II).** Үндэсний парк: Үндэсний болон олон улсын ач холбогдол бүхий байгалийн экосистемийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх зорилготой газар нутаг. Энд боловсрол, шинжлэх ухааны зорилгоор ашиглах, судалгаа шинжилгээ хийх, амралт сувилал байгуулах, аялал жуулчлалын тохиромжтой төрлийг хөгжүүлж болдог;
4. **Natural Monument (IUCN III).** Байгалийн дурсгалт газар: Байгалийн өвөрмөц онцлог бүхий үндэсний ач холбогдолтой газар нутаг. Энэ нь харьцангуй бага талбайг эзлэх бөгөөд зөвхөн хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагааг зөвшөөрдөг;
5. **Habitat/Species Management Area (IUCN IV).** Амьдрах орчин/төрөл зүйлийн менежментийн бүс: Энэ газар нутаг нь зөвхөн тодорхой төрөл зүйлийг болон түүний амьдрах орчныг хамгаалахад чиглэгддэг. Төрөл зүйл, түүний амьдрах орчныг хамгаалахад чиглэгдсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж болдог;
6. **Protected landscape/seaspace (IUCN V).** Хамгаалагдсан ландшафт/далайн ландшафт: Нийтийн ашиг сонирхлыг хангахуйц ашиглалтын менежментийн бодлого явуулах бөгөөд байгалийг хамгаалах, хүн байгалийн зохистой харилцаа үүсгэхэд чиглэгдсэн газар юм. Байгалийн нөөцийг зохистой, тогтвортой ашиглах боломжтой;
7. **Protected Area with sustainable use of natural resources (IUCN VI).** Байгалийн нөөцийг зохистой ашиглах тусгай хамгаалалттай газар нутаг: Эдийн засгийг дэмжих зорилгоор тасралтгүй үйлдвэрлэлийн явцад байгалийг нөхөн сэргээх, хамгаалах бодлогыг хамтад нь хэрэгжүүлдэг.

Мөн түүнчлэн НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO, ЮНЕСКО)³⁰⁰-аас ач холбогдлоороо бүх хүн төрөлхтний “нийтлэг үнэт зүйлс” (Common Goods) гэж тооцогдох байгаль, түүх, соёлын дурсгалт газруудыг тодорхойлох, хамгаалах, хадгалах ажлыг хийдэг бөгөөд зарим тусгай хамгаалалттай газар нутагт ЮНЕСКО-оос дор дурдсан тусгай статус олгодог байна. Үүнд:

1. **Biosphere Reserve.** Шим мандлын нөөц газар: Тус газар нутаг нь Хүн ба шим мандлын хөтөлбөрийн (MAB) дагуу ЮНЕСКО-оос тогтоосон бүс нутаг юм. Эдгээр нөөцийг биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой хөгжил, хүн ба байгаль орчны зохицолтой харилцааг дэмжих зорилгоор байгуулдаг.

³⁰⁰ <https://whc.unesco.org>

МАВ хөтөлбөр нь биологийн болон соёлын олон янз байдлыг хамгаалахдаа байгалийн нөөцийг зохистой ашиглах явдалтай уялдуулах зорилготой.

2. **World Heritage Site (UNESCO).** Дэлхийн өвийн хамгаалалттай газар: Хүн төрөлхтөнд үзүүлэх ач холбогдлоор нь соёлын, байгалийн болон холимог (соёлын болон байгалийн) өв хэмээн ЮНЕСКО хүлээн зөвшөөрсөн газар нутаг юм. Энэ бүс нутагт сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр үйл ажиллагаа явуулах ба хэрвээ аливаа нэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах бол дэлхийн олон улсын байгаль хамгаалах байгууллагуудаас зөвшөөрөл авах ёстой. Эдгээр газар нутаг хүн төрөлхтний нийтлэг өв гэсэн үг юм.
3. **Global Geopark (UNESCO).** Дэлхийн геопарк: геологийн өв, боловсрол, хамгаалал, тогтвортой хөгжлийн хувьд ач холбогдлоор нь ЮНЕСКО-гоос хүлээн зөвшөөрөгдсөн бүс нутаг юм. Эдгээр геопаркууд нь дэлхийн динамик үйл явцын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүний үйл ажиллагаа болон байгаль дэлхий хоёрын хоорондын харилцан хамаарлыг судлан тогтоох, тогтвортой хөгжлийн туршлагыг дэмжих зорилготой юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээрх олон улсын хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж байна. Монголын Улсын төдийгүй бүс нутаг, цаашлаад дэлхий дахины экологийн тэнцлийг хангахад чухал нөлөө бүхий байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны онцгой ач холбогдолтой Тусгай хамгаалалттай газар нутгуудыг олон улсын хүн ба шим мандлын нөөц газар (МАВ)-ын сүлжээ болон дэлхийн байгаль, соёлын өв (World heritage Site)-ийн жагсаалтад хамруулах болон цаашид хамруулах үндэслэлийг боловсруулж холбогдох газруудад санал болгох зэрэг арга хэмжээг Монгол Улс шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

ЮНЕСКО-ын Дэлхийн хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ (МАВ)-нд Говийн их ДЦГ 1991 онд, Богдхан уулын ДЦГ 1996 онд, Увс нуурын ай савын ДЦГ 1997 онд тус тус орсон.

Дэлхийн соёлын болон байгалийн өвийн жагсаалтад Увс нуурын ай савын ДЦГ, Говь гурван сайхны БЦГ-ын цөлийн эртний орд, Говийн их ДЦГ-ын А хэсэг, Хөвсгөл нуурыг бөө мөргөлтэй цаатангуудын нутгийн хамт, Отгонтэнгэр уул, Бурхан халдун уул, Богдхан уулын ДЦГ зэрэг газруудыг үе шаттайгаар хамруулах чиглэлийг баримтлан ажиллаж байна.³⁰¹

Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенцын хавсралт жагсаалтад Монгол дагуурын ДЦГ 1997 онд, Тэрхийн цагаан нуур, Өгий нуур, говийн нууруудын хөндий, Орог нуур, Таацын цагаан нуур, Бөөн

³⁰¹ Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Б.Оюунгэрэл, УБ 2004 он, 13 дахь тал

цагаан нуур, Адгийн цагаан нуурыг 1998 онд, Хар ус нуурын БЦГ 1998 онд, Айраг нуур 1999 онд тус тус бүртгэгдсэн байна.

Зүүн хойд азийн тогоруу хамгаалах олон улсын сүлжээнд Монгол дагуурын ДЦГ 1997 онд, Зүүн хойд азийн галуу нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээнд Тэрхийн цагаан нуур, Өгий нуурууд 1999 онд тус тус бүртгэгдсэн байна. Мөн хөрш зэргэлдээ орнуудтай хамтран хоёр болон гурван талын хил дамжсан хамтарсан ДЦГ-уудыг байгуулсан байна.

Монголын Монгол дагуурын дархан цаазат газар, Хятадын далай нуурын дархан цаазат газар, Оросын Даурскын дархан цаазат газруудыг хамарсан гурван улсын яам хоорондын хэлэлцээрээр 1994 онд байгуулсан.

Увс нуурын ай савын дархан цаазат, Хөвсгөлийн БЦГ-уудыг ОХУ-ын хил дагуух Тусгай хамгаалалттай газар нутагтай хамтад нь Монгол, Оросын хамтарсан ДЦГ болгон хамгаалалтад авсан байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)³⁰²-аас дэлхийн нийтийн хэмжээнд зайлшгүй хамгаалах шаардлагатай 200 эко бүс нутгийг тогтоогоод байгаа бөгөөд эдгээр бүс нутгийг хамгаалж чадвал 21-р зуунд дэлхийн биологийн төрөл зүйлийн 95%-ийг устгах аюулаас сэргийлж чадна гэж үзсэн. Энэ 200 эко бүсэд манай улсаас Дагуурын хээр тал, Алтай соёны уул нурууд багтдаг байна.

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх, менежментийг сайжруулахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх хүрээнд олон улсын байгууллага, гадаад улсуудаас дараах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байсан буюу хэрэгжүүлж байгаа болно³⁰³. Үүнд:

- НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүгийн дэмжлэгээр “Дорнод монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах ба тогтвортой хөгжлийн арга зам” төслийг 1998 оны 1 сараас 7 жилийн хугацаатай;
- Дэлхийн байгаль хамгаалах сангийн төсөл нь дэлхийн онцгой анхаарлын 200 бүс нутгийн сүлжээнд орсон 2 газар нутгийг, мөн 1998 онд Хар ус нуурын БЦГ-ын хамгаалалтын салбарыг бэхжүүлэх, мэдээлэл сурталчилгааны төв байгуулах;
- ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг GTZ (GIZ)-ийн байгаль хамгаалал ба орчны нутгийн хөгжлийн төсөл нь Хангайн нурууны БЦГ, Ханхэнтийн ДЦГ, Горхи тэрэлжийн БЦГ, Говь гурван сайханы БЦГ-т орчны бүсийн хөгжил, байгаль хамгаалах чиглэлээр 15 жижиг төсөл хэрэгжүүлсэн;

³⁰² <https://mongolia.panda.org/en/>

³⁰³ <https://www.met.gov.mn/pages/show/odoo-heregzhizh-bajgaa-t-sl-dijn-talaarh-medeelel/mn>

- Дорнод монголын тал хээрийн биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглалт ба хамгаалалт төслийг хэрэгжүүлж байна;
- Гал түймрээс хамгаалах нэгдсэн менежмент төсөл 1998 оноос Ханхэнтийн ДЦГ-т орчны бүсийн иргэдийг гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, унтраах арга барилд сургах үйл ажиллагаа;
- Хустай БЦГ-т Нидерланд улсын засгийн газрын санхүүжилтээр тахь хамгаалах өсгөн үржүүлэх;
- Хөвсгөлийн БЦГ-ын менежментийг бэхжүүлэх төслийг АНУ-ын дотоод хэргийн департамент, олон улсын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлсэн;
- “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” 1-3 дугаар үе шат, NO 2012 65 511 төсөл, 1-р үе шат: 15,3 сая евро. 2,3-р үе шат: 32,8 сая евро Буцалтгүй тусламж (ХБНГУ-ын Засгийн газар, Сэргээн босголтын зээлийн банк);
- Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь төсөл (SPACES), 4,5 сая еврогийн Техник туслалцаа (ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам).

1.3.Эрх зүйн орчин

Монгол Улсад Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин дараах хууль, эрх зүйн актуудаас бүрдэж байна.³⁰⁴ Үүнд:

- Үндсэн хууль;
- Газрын тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль;
- Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Олон улсын конвенцууд;
- Бодлогын баримт бичиг, бусад журам, дүрэм.

Монгол Улсын Үндсэн хууль: Тус хуулийн зургадугаар зүйлийн “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.”, Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба *улсын тусгай хэрэгцээнийхээс* бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд...” хэмээсэн заалтууд нь Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалтын эрх зүйн эх үндэс юм.

³⁰⁴ <https://legalinfo.mn/mn>

Газрын тухай хууль: Тус хуульд Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байх бөгөөд түүний нэг хэлбэр нь тусгай хамгаалалттай газар нутаг байхаар заасан.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль: Тус хууль 1994 оны 11 дүгээр сарын 15-нд батлагдаж, 1995 оны 04 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хууль нь 8 бүлэг 44 зүйлтэй. Өнгөрсөн хугацаанд тус хуульд нийт 17 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хамгийн сүүлд 2023 оны 05 дугаар сарын 04-нд нэмэлт, өөрчлөлт орсон байна. Тус хуулиар газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Хуульд тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, дотоод бүсчлэл, тус бүрийн хамгаалалтын дэглэм, тэдгээрт зөвшөөрөх болон хориглох үйл ажиллагаа, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах, судалгаа, шинжилгээний ажил явуулах журам зэргийг тусгасан.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль: Тус хууль 1997 оны 10 дугаар сарын 23-нд батлагдсан, 11 зүйл бүхий хууль юм. Нийт 2 удаа өөрчлөлт орсон. Энэ хуулиар тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүс, орчны бүсийг тогтоох шалгуур, орчны бүсийн зөвлөл, сан, менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай зэрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан.

Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Олон улсын конвенцууд:³⁰⁵

- Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Рамсарын конвенц, 1972): Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай уг конвенцод манай улс 1998 оны 4 сарын 8-ны өдөр албан ёсоор нэгдэн орж, 104 дэх гэрээлэгч тал болсон. Конвенцод нэгдэн орсон талууд Рамсарын конвенцын бодлого гаргадаг үндсэн нэгж бөгөөд Талууд нь тухайн улс орны Засгийн газрын байгууллага байдаг. Монгол Улсыг Рамсарын конвенцод төлөөлөх эрхтэй тал бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам юм. Монгол Улс 2021 оны байдлаар нийт 1,439,530га талбайг хамарсан 11 ус, намгархаг газрыг Рамсарын конвенцын хавсралтад бүртгүүлээд байна. Бусад газар нутгийн тухайд тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын дагуу зохих дэглэмийн хүрээнд хамгааллын үйл ажиллагаануудад хамрагдаж байна. Монгол Улс конвенцод нэгдэн орсон орны хувьд хүлээсэн үүргийнхээ хүрээнд ус, намгархаг газруудын хамгааллын менежментийг хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн тайлангаа хүргүүлж, конвенцын үйл ажиллагаанд тогтмол оролцож байна.

³⁰⁵ https://www.feu.awsassets.panda.org/downloads/conventions_final.pdf

- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц (CITES1975, Вашингтон): Энэхүү конвенцод Монгол Улс 1996 оны 4 дүгээр сарын 4-нд нэгдэн орж Конвенцод нэгдэн орсон 133 дахь тал болсон. Монгол Улсаас Хавсралт 1 ба 2-т нийлээд 14 зүйлийн хөхтөн, 71 зүйлийн шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас, 1 зүйл шавж, 1 зүйл мөлхөгч орсон. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохицуулах үүрэгтэй Удирдан зохицуулах зөвлөл, Шинжлэх ухааны зөвлөлийг конвенцын 9 дүгээр зүйлийн 1.6 заалтын дагуу мөн “Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуулийн 2, 4 дэх заалт, “Амьтны аймгийн тухай” хуулийн 23, 24 дүгээр зүйл, “Байгалийн ургамлын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн байгуулаад ажиллаж байна.
- Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенц (CMS 1983, Бонн): Монгол Улс энэхүү конвенцод 1999 оны 11 дүгээр сарын 1-нд албан ёсоор нэгдэн орж махчин шувууд, монгол бөхөн, цагаан тогоруу хамгаалах чиглэлээр харилцан ойлголцлын санамж бичигт хамтрагч тал болон орсон байна.
- Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD 1992, Рио Де Жанейро): Монгол Улсын Ерөнхий сайд 1992 онд Рио де Жанейро хотод хуралдсан НҮБ-ын Байгаль орчин ба Хөгжил Бага хурлын үеэр уг Конвенцод гарын үсэг зурж, Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 6 дугаар сарын 1-ний өдөр соёрхон баталж тус конвенцод нэгдэн орсон анхны 30 орны нэг болсон. Энэхүү конвенцод дэлхийн 190 гаруй орон нэгдэн орсон нь байгаль орчны асуудлаар урьд өмнө нь хэрэгжиж байсан аливаа олон улсын гэрээ, хэлэлцээрээс агуулга, хамрах хүрээний хувьд хамгийн том болгосон байна.³⁰⁶

Бодлогын баримт бичиг, бусад журам, дүрэм: 1992 онд зохион байгуулагдсан НҮБ-ын “Байгаль орчин ба Хөгжил” сэдэвт Бага хуралд Монгол Улс тогтвортой хөгжлийн анхны илтгэлээ танилцуулж газар нутгийнхаа 30-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах нэн чухал санаачилгыг дэвшүүлсэн бөгөөд энэ нь төрийн дараах бодлогын баримт бичгүүдэд тусаж ирсэн.³⁰⁷ Үүнд:

- Биологийн төрөл зүйлийн үндэсний хөтөлбөр (1996);
- Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998);
- Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1998);
- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008);

³⁰⁶ <https://met.gov.mn/pages/show/konvencijn-heregzhiltijn-medeel-tajlanguud/mn>

³⁰⁷ https://conservationstandards.org/wpcontent/uploads/sites/3/2021/03/PA_management_plan_tool_2021.01.26_approved.pdf

- Ус үндэсний хөтөлбөр (2010);
- Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010);
- Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр (2011);
- Ногоон хөгжлийн бодлого (2014);
- Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025), (2015);
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030 (2016)
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020).

Өнөөдөр Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх Төрийн бодлого, хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх хүрээнд эрх бүхий байгууллагууд 30 орчим дүрэм, журам, зааврыг батлан хэрэгжүүлж байна.

1.4.Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын тогтолцоо, бүрэн эрх

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын тогтолцоо нь дараах төрийн байгууллагуудаас бүрдэнэ.³⁰⁸ Үүнд:

- Улсын Их Хурал;
- Засгийн газар;
- Асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага;
- Орон нутгийн Хурал;
- Орон нутгийн Засаг дарга;
- Хамгаалалтын захиргаа;
- Байгаль хамгаалагч.

Эдгээр төрийн байгууллагууд тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дор дурдсан дараах бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлдэг байна.

Улсын Их Хурлын бүрэн эрх:

- газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах талаар төрийн бодлогыг тодорхойлох;
- Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.

³⁰⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=479>

Засгийн газрын бүрэн эрх:

- тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;
- тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эдийн засаг, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж энэ асуудлаар Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;
- тусгай хамгаалалттай газар нутгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах;
- тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хөгжүүлэх, экологийн аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- энэ хуульд заасан хамгаалалтын дэглэмийн хүрээнд тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг батлах;
- байгалийн нөөц газрын болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүрэн эрх:

- тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах;
- биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох;
- ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, хөтөлбөрийг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох;
- хортон шавж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх журам, аргачлал тогтоох, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг багасгах арга хэмжээ авах;
- рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай бусад эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглах журам, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлын жагсаалт, тэдгээрийг түүж бэлтгэх журмыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох;

- аялал, жуулчлалын зам, чиглэл, журам тогтоох;
- тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах;
- тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох;
- зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь томилох.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх:

- өөрийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг даргын илтгэлийг хэлэлцэж зохих шийдвэр гаргах, түүний биелэлтийг хангуулах;
- нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг дээд шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу Засгийн газарт уламжлах;
- нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох.

Орон нутгийн Засаг даргын бүрэн эрх:

- тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах талаар санал боловсруулж зохих байгууллагад уламжлах;
- байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх.

Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны эрх хэмжээ:

- тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах;
- судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;
- зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

- ан амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон биотехникийн бусад арга хэмжээг зохих журмын дагуу гүйцэтгэх;
- рашаан,эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг зохих журмын дагуу ашиглуулах;
- зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах;
- зөвшөөрөгдсөн бүс дэх сууриныг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;
- уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах;
- тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын горим, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, он дарааллын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;
- зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж,байгууллагад ашиглуулах газрыг тогтоох.

Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг:

Хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байна. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх;
- хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх;
- хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах;
- хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих;
- албан үүргээ гүйцэтгэх үедээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг, зэвсэг, хэрэгсэлтэй байх.

1.5.Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээ

Монгол Улс нийт газар нутгийнхаа:

- 1995-2000 онд 15%
- 2001-2005 онд 20%
- 2006-2010 онд 25%
- 2011-2030 онд 30%-ийг улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн.

Өнөөгийн байдлаар Монгол орны газар нутгийн 21 хувь буюу 32.8 сая га талбай бүхий 120 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан байна. Үүнээс: дархан цаазат газар 22, байгалийн цогцолборт газар 37, байгалийн нөөц газар 47, дурсгалт газар 14 байна.

Эдгээрээс Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа 34 хамгаалалтын захиргаа 22 дархан цаазат газар, 34 байгалийн цогцолборт газар, 6 байгалийн нөөц газар, 2 дурсгалт газрыг улсын төсвийн хөрөнгөөр хамгаалалтын менежментийг хариуцаж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 49, 2023 оны 125 дугаар тогтоолоор Хомын талын байгалийн цогцолборт газрыг “Хомын тахийн тал” НҮТББ, Хустайн байгалийн цогцолборт газрыг “Хустай цогцолборт газар” төв ТББ хамгаалалтын менежментийг хариуцаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт аймгийн Засаг дарга “байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг эрхлэх”, 5 дахь хэсэгт “орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах” гэж заасны дагуу Хурх хүйтний хөндийн байгалийн нөөц газрыг Зэрлэг амьтан судлах хамгаалах төв ТББ Хэнтий аймгийн Засаг дарга, Батширээт, Баян-Адрага, Биндэр сумын Засаг даргатай гэрээгээр, Их нартын байгалийн нөөц газрыг “Их нартын менежмент” ТББ Дорноговь аймгийн Засаг даргатай орон нутгийн төсвөөс, Хар ямаатын байгалийн нөөц газрыг Хэнтий аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр, Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрыг Өмнөговь аймаг, Ирвэс хамгаалах сан болон уул уурхайн дүйцүүлэн хамгааллын зардлаар “Ирвэс хамгаалах сан” ТББ, орон нутгийн хамгаалалтын захиргаа хамтран, мөн Дорнод аймгийн байгалийн нөөц газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг Дорнод аймгийн Засаг даргатай Дорнод ОНӨҮГ гэрээгээр тус

тус хариуцаж байна. Зарим аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газар 28 байгалийн нөөц газар, 8 дурсгалт газрын менежментийг тус тус хариуцаж байна.

Зураг 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ



Эрдэмтдийн судалгаагаар манай орны өндөр уулын экосистемийн **13.7** хувь, ойт хээрийн экосистемийн **6.0** хувь, тал хээрийн **6.0** хувь, цөлийн экосистемийн **23.5** хувь, мөн ховордсон, устгах аюулд ороод байгаа амьтан, ургамлын тархац нутгийн **40** орчим хувь улсын тусгай хамгаалалтад хамрагдсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол

Монгол орон өргөн уудам нутаг дэвсгэртэй, асар их байгалийн баялагтай учраас газар болон байгалийн нөөцөө аль болох их хэмжээгээр ашиглаж байж Монгол Улс хөгжинө гэж ихэнх хүмүүс үздэг. Мөн нөгөө талаар газар нутгийг тусгай хамгаалалтад авснаар орон нутгийн уугуул иргэдийн эрхийг ямар нэг хэмжээгээр хязгаарлаж байна гэх асуудал ч бас яригддаг. Хэрвээ зөвхөн өнөө маргаашийн эрх ашгийн үүднээс харвал үнэхээр тийм мэт боловч алс ирээдүй хувьд тийм биш ажээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол нь байгаль орчин, экологи, нийгэм, эдийн засгийн олон талт, өргөн хүрээг хамардаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол нь.³⁰⁹

1. Биологийн олон янз байдлыг хамгаалах: Тусгай хамгаалалттай газар нутаг нь олон төрлийн ургамал, амьтны төрөл зүйлийн хувьд “хоргодох газар” нь болж, биологийн олон янз байдлыг хамгаалан нэн ховор буюу эмзэг амьтдыг устгах аюулаас сэргийлэхэд

³⁰⁹ Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Б.Оюунгэрэл, УБ 2004 он, 42-43 дахь тал

тусалдаг байна. Монголын нийт газар нутгийн 70% нь эрчимтэй ашиглалтын бүс нутагт хамрагдах тохиолдолд 30% ийг нь бид ирээдүй хойч үедээ үлдээх ёс суртахууны хариуцлага хүлээх ёстой.

2. Экосистемийг хамгаалах: Ой, нуур цөөрөм, намаг, уул толгод гэх мэт байгалийн унаган экосистемийг хадгалах, хамгаалахад тусгай хамгаалалттай газар чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр экосистемүүд нь экологийн тэнцвэрт бөгөөд уян хатан байдлыг хадгалан хамгаалахад тусалдаг байна.
3. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох: Тусгай хамгаалалттай газар нутаг нь нүүрстөрөгчийг шингээдэг экосистемийг хамгаалах замаар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чухал хувь нэмэр оруулдаг. Мөн түүнчлэн экосистемийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах замаар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг дээшлүүлдэг байна.
4. Усны нөөцийг хамгаалах: Олон тусгай хамгаалалттай газар нутаг усны урсцыг зохицуулах, усны чанарыг хадгалах, усны хагалбаруудыг хамгаалахад тусалж, цэвэр усны нөөцийг тогтвортой хангахад бодит хувь нэмэр оруулдаг.
5. Байгаль, соёлын өвийг хамгаалах: Зарим тусгай хамгаалалттай газар нутаг нь соёл, түүхийн ач холбогдолтой байдаг. Тэдгээр газрууд нь нутгийн уугуул иргэд болон тэдгээрийн хүй элгэний өвөрмөц соёл, ахуйн чухал ач холбогдолтой газруудыг хадгалан авч үлдэхэд чиглэгддэг. Тэдгээр нь хүн төрөлхтний соёлын өв, уламжлалт зан үйлийг хадгалахад хувь нэмэр болдог байна.
6. Амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх: Тусгай хамгаалалттай газар нутгууд нь хээрийн амралт, аялал жуулчлалын боломжийг нээж, танин мэдэхүйн болон амралт зугаалгын хосолсон бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгохын зэрэгцээ тогтвортой, хариуцлагатай аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.
7. Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ хийх: Тусгай хамгаалалттай газар нутаг нь шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ хийх “амьд” лабораторийн үүрэг гүйцэтгэж, эрдэмтэн, судлаачдад байгалийн үйл явц, биологийн олон янз байдал, экосистемийг судалж, байгаль ертөнцийн талаарх бидний мэдлэгт хувь нэмэр оруулах боломжийг олгодог.
8. Байгаль орчны боловсрол, мэдлэг олгох: Тусгай хамгаалалттай газар нутаг нь олон нийтэд хүрээлэн буй орчны талаарх системтэй боловсрол олгож, байгалиа хайрлан хамгаалах ухамсар, зан үйл, төлөвшлийг бий болгоход чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл хүрээлэн буй орчны боловсролын “амьд” үзүүлэн бүхий платформ юм.
9. Хөдөө аж ахуй, ан агнуурын тогтвортой байдал бий болгох: Тусгай хамгаалалттай газар нутаг нь тухайн экосистем болон орон нутгийн эдийн засагт аль алинд нь ашиг тустай байх тогтвортой

сайн туршлагыг дэмжих, эсхүл тусгай орчны бүс бий болгох замаар хөдөө аж ахуй, ан агнуурт тогтвортой хувь нэмрээ оруулж чаддаг байна. Олон нийтийн боддогчлон тусгай хамгаалалтай газарт ашиглалтыг бүрэн хориглодог гэсэн үг биш бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн бүсэд уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх, байгалийн дагалт баялаг ашиглах, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах эрхийг хангадаг.

10. Соёл, оюун санааны үнэт зүйлс: Олон тусгай хамгаалалттай газар нь тухайн нийгэмдээ оюун санааны болон соёлын чухал ач холбогдолтой байх нь бий. Тэдгээр нь ард иргэдийн сайн сайхан аж амьдралын мэдрэмж, үндэсний өвөрмөц онцлог байдлыг тус тус тодруулах, товойлгоход чухал хувь нэмэр оруулдаг ажээ.
11. Эдийн засгийн тогтвортой байдал: Тусгай хамгаалалттай газар нутаг нь эко аялал жуулчлал, хээрийн амралт, зугаалгыг хөгжүүлэх, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах замаар эдийн засгийн үр өгөөжийг бий болгож байдаг. Энэ нь орон нутгийн эдийн засагт байнгын дэмжлэг болдог экосистемийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх ач холбогдолтой юм.
12. Байгалийн гамшгийн хор уршгийг арилгах: Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эрүүл, унаган экосистем нь үер ус, салхи шуурга, ган, зуд зэрэг байгалийн болзошгүй гамшгаас хамгаалах “байгалийн хамгаалалт”-ыг бий болгож, тусгай хамгаалалт бүхий газрын ойр орчмын хүн амд гамшгийн үзүүлэх нөлөөллийг бууруулж байдаг байна.

Эцэст нь онцлон дурдахад, байгаль хамгаалах хүчин чармайлтыг орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан хослуулах нь тухайн Тусгай хамгаалалттай газар нутгийн урт хугацааны үр өгөөж, үр нөлөөг хангах нэн чухал бөгөөд тогтвортой, хүртээмжтэй менежментийн арга хандлага юм гэж олон улсын байгууллага, эрдэмтэн, судлаачид үзэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁР.ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛАЛ, ДОТООД БҮСЧЛЭЛ ТЭДГЭЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ

Тусгай хамгаалалттай газар нутаг нь **Улсын тусгай хэрэгцээний газрын** нэг хэлбэр юм. Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлд улсын тусгай хэрэгцээний газрын эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг. Түүнчлэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар Тусгай хамгаалалттай газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг гэж ангилж үзэж болно.

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. дархан цаазат газар;
2. байгалийн цогцолборт газар;
3. байгалийн нөөц газар;
4. дурсгалт газар.

2.1.Дархан цаазат газар

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ. Монгол Улсын хэмжээнд дараах **22** газар нутгийг дархан цаазат газрын ангилалд хамруулсан байна.


Хүснэгт 1. Дархан цаазат газар (ДЦГ)-ууд

	Дархан цаазат газар	Тайлбай (га)
1	Алтан элс	150,143
2	Түргэн уул	130,473
3	Увс нуурын ДЦГ	441,223
4	Хасагт хайрханы ДЦГ	48,394
5	Хөх сэрхийн нурууны ДЦГ	65,920
6	Цагаан шувуут уул	33,304
7	Богдхан уулын ДЦГ	-
8	Ноён уулын ДЦГ-1	22,313
9	Ноён уулын ДЦГ-2	-
10	Хан Хэнтийн ДЦГ	1,748,104
11	Говийн бага /А/ ДЦГ	-

11	Говийн бага /Б/ ДЦГ	1,800,000
11	Говийн их /А/ ДЦГ	4,613,300
14	Говийн их /Б/ ДЦГ	1,835,721
15	Дорнод Монголын ДЦГ	570,300
16	Монгол дагуур /А/-ын ДЦГ	190,400
17	Монгол дагуур /Б/-ын ДЦГ	
18	Нөмрөгийн ДЦГ	587,380
19	Зэд-Хантай-Бүтээлийн нурууны ДЦГ	605,009
20	Отгонтэнгэрийн ДЦГ	89,826
21	Улаан тайгын ДЦГ	434,900
22	Хорьдол сарьдагийн ДЦГ	227,413
	Нийт	13,594,122

Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс гэсэн 3 дотоод бүсэд хуваадаг. Эдгээр дотоод бүсчлэл нь тухайн бүсэд мөрдөх хамгаалалтын дэглэмээр тодорхойлогдоно.

Зураг 2. Дархан цаазат газрын дотоод бүс



Дархан цаазат газрын хамгаалалтын дэглэм:

Онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх бөгөөд байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулахаас бусад бүх төрлийн үйл ажиллагааг хориглодог. Харин хамгаалалтын бүсэд дээр дурдсан судалгаа шинжилгээний ажлаас гадна ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг зөвшөөрдөг бол хязгаарлалтын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгөөр дараах үйл ажиллагаа явуулж болдог:

- 1/ Онгон, хамгаалалтын бүсэд заасан үйл ажиллагаа;
- 2/ хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;
- 3/ ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;
- 4/ ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах;
- 5/ рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах;
- 6/ байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах;
- 7/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;
- 8/ зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах;
- 9/ уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх;
- 10/ нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах.

Дархан цаазат газарт дээр дурдсанаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглодог:

- 1/ газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;
- 2/ байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;
- 3/ ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулахаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;

4/ хортон шавж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх;

5/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглахаас өөр барилга байгууламж барих;

6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;

7/ тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах;

8/ аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;

9/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;

10/ нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;

11/ хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

Дархан цаазат газруудад уламжлалт мал аж ахуй эрхэлж буй малчин өрх, тэдгээрийн мал сүрэг, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн тоог харуулбал:

Хүснэгт 2. ДЦГ дахь малчин өрхийн судалгаа

Тусгай хамгаалалттай газрын ангилал	Дархан цаазат газар
Дархан цаазат газрын тоо	22
Уламжлалт мал аж ахуй эрхлэдэг өрхийн тоо	710
хүний тоо	2406
малын тоо	461416
Өвөлжөө	585
Хаваржаа	247
Намаржаа	34
Зуслан	317
Тайлбар	Дархан цаазат газруудаас Хасагт хайрхан, Цагаан шувуут уул, Богдхан уул, Говийн их /А/, Говийн их дархан цаазат газар /Б/ зэрэг 5 газарт МАА эрхэлдэггүй. Эдгээрээс Говийн их /А/, Говийн их /Б/ дархан цаазат газруудад 42 өвөлжөө, 31 хаваржаа байдаг ба дархан цаазтай болгохоос өмнө зөвшөөрөл олгогдсон, одоогоор зөвшөөрлийн хугацаа дуусаагүй боловч дархан цаазат газар тул ашигладаггүй.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам,
Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар

2.2.Байгалийн цогцолборт газар

Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ. Монгол Улсын хэмжээнд дараах **37** газар нутгийг байгалийн цогцолборт газарт хамруулсан. Үүнд:

Хүснэгт 3. Байгалийн цогцолборт газар (БЦГ)-ууд

	Байгалийн цогцолборт газар
1	Алтай таван богд
2	Ачит нуур Дэвэлийн арал
3	Булган голын эх-Их онгог
4	Говь гурван сайхан
5	Горхи-Тэрэлж
6	Гутайн даваа хөмүүл голын эх
7	Дарьганга
8	Заг Байдрагийн голын эхэн сав
9	Их Богд уул
10	Их газрын чулуу
11	Молцог элс
12	Монгол элс
13	Мөнххайрхан уул-Үенчийн хавцал
14	Мянган-Угалзат
15	Ноён хангай
16	Онон - Балж /А/
17	Онон - Балж /Б/
18	Орхоны хөндий
19	Өндөрхаан уул
20	Сийлхэмийн нуруу /А/
21	Сийлхэмийн нуруу /Б/
22	Тарвагатайн нуруу
23	Тужийн нарс
24	Тэнгис-Шишгэд
25	Тэсийн гол, Булнайн нуруу
26	Улаагчины хар нуур
27	Хан хөхийн нуруу
28	Хангайн нуруу
29	Хар ус нуур
30	Хомын тал
31	Хорго - Тэрхийн цагаан нуур
32	Хөвсгөл
33	Хөгнө Тарна
34	Хустайн нуруу
35	Хяргас нуур
36	Цамбагарав уул
37	Чигэртэйн голын ай сав


Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараах бүсэд хуваадаг:

- 1/ онцгой бүс;
- 2/ аялал, жуулчлалын бүс;
- 3/ хязгаарлалтын бүс.

Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын дэглэм:

Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсөж үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авч болдог. Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр Дархан цаазат газар, БЦГ-ын онцгой бүсэд зөвшөөрөгдсөн ажиллагаа явуулах болон зөвшөөрөгдсөн газар загас барьж болдог.

Зураг 3. БЦГ-ын дотоод бүс



Хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулж болно:

- 1/ ДЦГ, БЦГ-ын онцгой, аялал жуулчлалын бүсэд зөвшөөрөгдсөн ажиллагаа явуулах;
- 2/ уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;
- 3/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих;
- 4/ батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах;
- 5/ биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засаж тохижуулах;
- 6/ тухайн нутаг дэвсгэр дэх сууриныг экологийн магадлан

шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх.

Байгалийн цогцолборт газарт ДЦГ, БЦГ-ын онцгой, аялал жуулчлалын бүсэд зөвшөөрөгдсөн ажиллагаа явуулахаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 1/ дархан цаазат газарт хориглосон үйл ажиллагааг явуулах;
- 2/ онцгой бүсэд заасан үйл ажиллагаа явуулах;
- 3/ батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурины нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих.

Байгалийн цогцолборт газруудад уламжлалт мал аж ахуй эрхэлж буй малчин өрх, тэдгээрийн мал сүрэг, өвөлжаа, хаваржөө, намаржаа, зуслангийн тоог харуулбал:

Хүснэгт 4. БЦГ дахь малчин өрхийн судалгаа

Тусгай хамгаалалттай газрын ангилал	Байгалийн цогцолборт газар
Байгалийн цогцолборт газрын тоо	37
Уламжлалт мал аж ахуй эрхлэдэг өрхийн тоо	9731
хүний тоо	36913
малын тоо	3026365
Өвөлжөө	4671
Хаваржаа	3504
Намаржаа	1370
Зуслан	20429
Тайлбар	Байгалийн цогцолборт газруудаас Молцог элс, Хустайн нуруу зэрэг 2 газарт МАА эрхэлдэггүй. Тэнгис-Шишгэдэд таван хошуу малаас гадна 2045 тооны цаа буганы аж ахуй эрхэлдэг.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар

2.3.Байгалийн нөөц газар

Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ. Монгол Улсын хэмжээнд **47** газар нутгийг байгалийн нөөц газар байхаар тогтоосон. Эдгээрээс дараах **6** газрын хамгаалалтын менежментийг улсын төсвөөр, бусад газруудын хамгаалалтын орон нутаг хариуцдаг байна. Үүнд:

Хүснэгт 5. Байгалийн нөөцийн газар (БНГ)-ууд

	Байгалийн нөөц газар
1	Нагалхаан уулын БНГ
2	Тосон хулстайн БНГ
3	Тост тосон бумбын БНГ
4	Тэсийн голын БНГ
5	Угтамын БНГ
6	Яхь нуурын БНГ

Байгалийн нөөц газрыг дараах төрөлд хуваана:

- 1/ байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар;
- 2/ ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар;
- 3/ эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар;
- 4/ газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар;
- 5/ Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар.

Байгалийн нөөц газрын дэглэм:

Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхэлж болох ба харин байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглодог байна.

Хамгаалалтын менежментыг улс хариуцдаг Байгалийн нөөц газруудад уламжлалт мал аж ахуй эрхэлж буй малчин өрх, тэдгээрийн мал сүрэг, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн тоог харуулбал:

Хүснэгт 6. БНГ дахь малчин өрхийн судалгаа

Тусгай хамгаалалттай газрын ангилал	Байгалийн нөөц газар
Байгалийн нөөц газрын тоо	6
Уламжлалт мал аж ахуй эрхлэдэг өрхийн тоо	551
хүний тоо	48830
малын тоо	58340
Өвөлжөө	80
Хаваржаа	35
Намаржаа	115
Зуслан	80
Тайлбар	Байгалийн нөөц газруудаас Тэсийн голд МАА эрхэлдэггүй.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар

2.4.Дурсгалт газар

Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ. Монгол Улсын хэмжээнд **14** газар нутгийг дурсгалт газраар тооцсон байдаг бөгөөд тэдгээрээс дараах **2** газрын хамгаалалтын менежментийг улсын төсвөөр, бусад газрыг орон нутаг хариуцан гүйцэтгэдэг байна. Үүнд:

Хүснэгт 7. Дурсгалт газар (ДГ)-ууд

	Дурсгалт газар
1	Хангал нуур
2	Биндэрьяа хан уул

Дурсгалт газрыг дараах төрөлд хуваадаг. Үүнд:

- 1/ байгалийн дурсгалт газар;
- 2/ түүх, соёлын дурсгалт газар.

Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баян бүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно.

Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

Дурсгалт газрын дэглэм:

Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна.

Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс О,1-3,О км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Улсын төсвийн санхүүжилтээр хамгаалалтын менежментийг нь хэрэгжүүлдэг Дурсгалт газруудад уламжлалт мал аж ахуй эрхэлж буй малчин өрх, тэдгээрийн мал сүрэг, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн тоог харуулбал:

Хүснэгт 8. ДГ-уудын малчин өрхийн судалгаа

Тусгай хамгаалалттай газрын ангилал	Дурсгалт газар
Дурсгалт газрын тоо	2
Уламжлалт мал аж ахуй эрхлэдэг өрхийн тоо	46
хүний тоо	164
малын тоо	36742
Өвөлжөө	38
Хаваржаа	22
Намаржаа	22
Зуслан	21

*Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам,
Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар*

2.5.Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ. Орчны бүс нь дархан цаазат газрын хилийн заагийн гадна байх бөгөөд байгалийн цогцолбор газрын хувьд түүний хилийн заагийн гадна буюу хязгаарлалтын бүстэй нь давхацсан байж болно. Орчны бүсийн заагийг тухайн газрыг тусгай хамгаалалтад авснаас хойш нэг жилийн дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоодог байна.

Орчны бүсийг тогтоохдоо экологийн, нийгэм, эдийн засгийн болон бусад шалгуурыг харгалзан үздэг:

Экологийн шалгуур:

- а. экологи, нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий биологийн төрөл, зүйлийг хамгаалах шаардлагатай газар нутаг;
- б. нэн ховор, ховор ан амьтны байршил, нутагшилт, тархац, тэдгээрийн нүүдлийн зам;
- в. нэн ховор, ховор ан амьтан нутагшаагүй боловч цаашид нутагшиж болох газар нутаг;

г. тусгай хамгаалалттай газрын байгаль орчинд онцгой нөлөө үзүүлэх гол, голын эх, сав газар.

Нийгэм, эдийн засгийн шалгуур:

а. тухайн тусгай хамгаалалттай газраас байгалийн баялаг ашиглан орлого олдог нутгийн иргэдийн амьдардаг газар нутаг;

б. байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн байршил, нөлөөллийн хүрээ;

в. нутгийн хүн ам, айл өрх, малын нягтрал нь бэлчээрийн даац, усны хангамжийн хүрэлцээнд сөрөг нөлөө үзүүлж байгаа газар нутаг;

г. нийгэм, эдийн засгийн хөгжил нь тухайн тусгай хамгаалалттай газар, түүний орчны байгаль, байгалийн нөөцөөс онцгой хамаарал бүхий суурин.

Бусад шалгуур:

а. байгалийн өвөрмөц тогтоц, онцлог бүхий газар нутаг;

б. түүх, соёлын дурсгалт зүйлс бүхий газар нутаг.

Орчны бүсийг тогтоохоос өмнө тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа харьяалах сум, дүүргийн Засаг даргатай хамтран тухайн асуудлаар нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, орчны бүс тогтоох зорилго, энэ талаар гарсан санал, орчны бүсийн тухай хууль тогтоомж, иргэдийн оролцооны тухай тайлбарлан танилцуулсан байх ёстой. Хамгаалалтын захиргаа орчны бүсийн Зөвлөлтэй хамтран орчны бүсийн зааг тогтоох саналыг боловсруулж, сум, дүүргийн Засаг даргад уламжилна. Сум, дүүргийн Засаг дарга саналыг хянан үзэж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулдаг байна.

Орчны бүсэд орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилго бүхий орон тооны бус орчны бүсийн зөвлөлийг ажиллуулдаг. Зөвлөл нь сондгой тооны гишүүдтэй байх бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна:

а. сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс хоёроос доошгүй төлөөлөгч;

б. нутгийн иргэдээс гурваас доошгүй төлөөлөгч;

в. хамгаалалтын захиргаанаас хоёр төлөөлөгч.

г. Зөвлөлд байгаль орчны чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөгч ажиллаж болно.

Орчны бүсийн зөвлөл дараах эрх, үүрэгтэй:

1. тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсэд хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих;

2. орчны бүсэд газар, байгалийн бусад баялаг ашиглахтай холбогдсон асуудлаар санал, зөвлөмж, төсөл, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах;

3. орчны бүсэд байгаль орчны тухай хууль тогтоомж, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Засаг даргад туслах, зөвлөх, санал тавих;

4. орчны бүсийн санд хөрөнгө төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

5. тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, зохих мэдээллийг олон нийтэд түгээх.

Орон нутгийн Засаг дарга нь хамгаалалтын захиргаа, зөвлөлтэй хамтран орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

а. нэн ховор, ховор ан амьтан, ургамал, түүнчлэн газар, байгалийн баялгийн хамгаалах, ашиглах чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ;

б. орчны бүсэд байгалийн нөөцийг зохистой ашиглах чиглэл, хэлбэр, уг үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүсэд үзүүлэх нөлөөллийг багасгах арга хэмжээ;

в. иргэдийн ажил эрхлэлт, нийгмийн асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ;

г. орчны бүсээр дамжин өнгөрдөг ан амьтан нүүдэллэх зам, түүнийг хамгаалах арга хэмжээ;

д. орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, санхүүжүүлэх эх үүсвэр.

2.6.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах

Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр хуульд заасан зөвшөөрлийн үндсэн дээр³¹⁰ гэрээгээр зөвхөн ашиглуулж болохоор заасан байна. Энэхүү зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгодог. Газар ашиглуулах гэрээний хугацаа 5 жилээс доошгүй байх бөгөөд хугацааг 1 удаа 5-аас доошгүй жилээр сунгаж болно.

³¹⁰ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail/479>

Тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмшүүлэхийг хориглодог. Түүнээс гадна гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглосон байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах тухай хүсэлт гаргах:

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуульд заасан журмыг баримтлан газар ашиглах зөвшөөрөл авах, сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлтээ тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд гаргана.

Тусгай хамгаалалттай газарт газар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээдтэй газар ашиглалтын талаарх гэрээг хэрхэн байгуулах вэ? Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага буюу яам хамгаалалтын захиргаатай хамтран газар ашиглах тухай гэрээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах бөгөөд тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах тухай гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэнэ. Гэрээндээ дараах зүйлсийг тусгана:

- тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;
- газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;
- газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;
- гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх журам.

Тусгай хамгаалалттай нутагт газар ашиглагчийн үүрэг:

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа аливаа иргэн, аж ахуйн нэгж нь Газрын тухай хуульд заасан ерөнхий үүргүүдээс гадна дараах үүргүүдийг хүлээдэг:

- тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;
- ашиглахаар авсан газартаа тогтоосон замаар орж, гарах;
- хууль, гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах;

- газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээж, засаж тохижуулан хамгаалалтын захиргаа, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

Газар ашиглагчдад хориглох үйл ажиллагаа:

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн, нэгж, байгууллагад дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- ашиглаж байгаа газраа бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулах;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэм, горимоор хориглосон болон гэрээнд зааснаас өөр буюу байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулах.

Хүснэгт 9. Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) дахь газар ашиглалтын судалгаа

№	Хамгаалалтын захиргааны нэр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Талбайн хэмжээ /га/
1	Хөгнө тарнын БЦГ	14	33.4
2	Горхи-Тэрэлжийн БЦГ	797	1,603.96
3	Онон-Балжийн БЦГ	3	82.2
4	Отгонтэнгэрийн УТХГ	5	15
5	Улаан тайгын УТХГ	3	3.84
6	Говь Гурван сайханы БЦГ	11	28.75
7	Богдхан уулын ДЦГ	1,859	3,018.3
8	Их Богдын БЦГ	1	2.9
9	Дарьгангын БЦГ	4	8
10	Хангайн нурууны БЦГ	24	51.6
11	Говийн бага ДЦГ	4	339.6
12	Их нартын БЦГ	2	1.83
13	Увс нуурын ай савын УТХГ	1	3
14	Хан Хөхийн нурууны УТХГ	10	26.9
15	Их газрын чулуу БЦГ	1	1.8
16	Орхоны хөндийн БЦГ	50	41.15
17	Хөвсгөлийн БЦГ	151	598.84
	Нийт дүн	2,940	5,861.07

ГУРАВ.ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горимын хүрээнд дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын онцгой, аялал жуулчлалын бүсэд уламжлалт мал аж ахуй эрхлэхийг хориглодог.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоодог байна.

Гэвч газар нутгийг тусгай хамгаалалтад авахаас өмнө тухайн орон нутагт оршин амьдарч байсан уугуул малчин өрхүүдийн мал сүрэг, өвөлжөө, хаваржааны асуудал ихээхэн маргаан дагуулдаг. Энэ нь нэгдүгээрт, малчид өвөлжөө, хаваржааныхаа газрыг нэгэнт эзэмшсэн байсан тохиолдолд олгогдсон тодорхой хугацааны турш тухайн газрын зөвшөөрөл хүчинтэй хэвээр байдаг. Хоёрдугаарт, Үндсэн хууль болон газрын тухай хуульд зааснаар газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авсан тохиолдолд тухайн эзэмшигч иргэнд улсаас нөхөн олговор олгох ёстой атал энэхүү нөхөн олговрын асуудлыг улсын төсөвт тусгаж шийдвэрлэдэггүй зэрэгтэй холбоотой юм.

Ингэснээр нэг талаас тусгай хамгаалалттай газар нутгийн хориглосон бүсэд зөвшөөрөлгүйгээр мал аж ахуй эрхэлж дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн хамгаалалтын дэглэм зөрчигдөх, нөгөө талаас малчин өрхийн Үндсэн хуулиар олгогдсон эрх хөндөгдөх нөхцөл байдалд хүрдэг байна.

Малчид гадаргын ус, хур тунадас, булаг, шанд, гүний худаг зэрэг усны нөөц болон бэлчээрт түшиглэж амьдардаг тул усны хомстол болон бэлчээрийн доройтол нь малчдын тогтвортой амьжиргаа, оршин сууж буй газар нутгийн экосистемд эрсдэл учруулж байгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр судалгаандаа тэмдэглэсэн байдаг.

Гэтэл бэлчээрийн доройтол, усны нөөцийн хомстолын үндсэн шалтгаан нь даацаас хэтэрсэн малын тоо толгойн хэт өсөлт гэдгийг шинжлэх ухааны холбогдох олон судалгаа, шинжилгээгээр нотолж байгаа билээ. Ийнхүү байгаль хамгааллын асуудал болон малчдын амьжиргааны асуудал нь харилцан уялдаатай, бие биедээ хүчтэй нөлөөлөл үзүүлдэг харилцан хамаарал бүхий асуудлууд тул цогц бодлого, шийдэл шаардлагатай байна. Байгаль хамгаалах хүчин чармайлтыг орон нутгийн

иргэдийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан хослуулах нь тухайн Тусгай хамгаалалттай газар нутгийн урт хугацааны үр өгөөж, үр нөлөөг хангах нэн чухал бөгөөд тогтвортой, хүртээмжтэй менежментийн арга хандлага юм гэж олон улсын байгууллага, эрдэмтэн, судлаачид үзэж байна.

Түүнчлэн Байгаль орчны тухай багц хуульд тухайн зохицуулж буй харилцаанд оролцох төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагын эрх, үүргийг тодорхой заасан ч төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх чадавх сул, байгууллага, түвшин, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүйн улмаас хуулийн болоод хүний эрхийн хэрэгжилтийг аль алийг нь бүрэн хангахад бэрхшээл тулгарч байна.

Засгийн газрын тухай хууль, Газрын тухай хуульд тусгасан газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой эрх хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яаманд давхардуулан өгчээ. Бүтэц зохион байгуулалт нь барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан яаманд шилжсэнээр улсын хэмжээнд газар зохион байгуулалтын цогц арга хэмжээний нэг хэсэг болох газар хамгаалах, нөхөн сэргээх ажил орхигдож байна.

Хууль тогтоомжийн хүрээнд байгаль орчныг хамгаалах төрийн үйл ажиллагаа дахь хууль дээдлэх зарчим “хангалттай” зохицуулагдсан боловч бодит байдалд тэр болгон биеллээ олж, үр дүнд хүрэхгүй байна. Иймд байгаль орчны салбарын бодлого чиглэлийг зөв тодорхойлох, эрх зүйн орчныг тодорхой, тогтвортой байлгах, мэдээллийн ил тод байдлыг хангах, бүх түвшинд хамтран ажиллах нь чухал юм. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, ажлын үр нөлөөг дээшлүүлж чанарын өөрчлөлт гаргах шаардлагатай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Үндсэн хууль
- Газрын тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль
- Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Д.Мягмарсүрэн, УБ 2000 он
- Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, Б.Оюунгэрэл, УБ 2004 он
- Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Д.Мягмарсүрэн, Д.Энэбиш (Ph.D), УБ 2007 он
- Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Д.Мягмарсүрэн, А.Намхай, УБ 2012 он
- Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх боломж, З.Батжаргал, З.Шийрэвдамба, УБ 2016
- БХОУХ: <https://www.iucn.org>
- ДТХГНХ: <https://www.iucn.org/our-union/commissions/world-commission-protected-areas>
- WWF: <https://mongolia.panda.org/en/>
- БОХЖЯ: <https://www.met.gov.mn/mn>
- <https://www.met.gov.mn/pages/show/odoo-heregzhizh-bajgaa-t-sl-dijn-talaarh-medeelel/mn>
- <https://legalinfo.mn/mn>
- ОУ-ын конвенцууд: https://wwfeu.awsassets.panda.org/downloads/conventions_final.pdf
- <https://met.gov.mn/pages/show/konvencijn-heregzhiltijn-medeelel-tajlanguud/mn>
- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=479>

ХАВСРАЛТ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ МАЛЧИН ӨРХҮҮД,
ТЭДГЭЭРИЙН МАЛЫН ТОО ТОЛГОЙН СУДАЛГАА³¹¹

d/d	Тусгай хамгаалалт-тай газар нутаг	Уламжлалт мал аж ахуй эрхэлдэг		Хамгаалалтын менежмент хэрэгжүүлэгч, Хамгаалалтын захиргааны нэр	Үүнээс				Нийт малын тоо	Үүнээс					
		Өрхийн тоо	Хүний тоо		Өөлжөө	Хаваржаа	Намаржаа	Зуслан		Үхэр	Адуу	Тэмээ	Хонь	Ямаа	
ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР															
1	Алтан элсний ДЦГ	15	46	Хан Хөхийн нурууны УТХГНХЗ	15	0	0	0	9500	560	630	0	4210	4100	
2	Түргэн уулын ДЦГ	23	75	Увс нуурын ай савын УТХГНХЗ	23	-	-	-	13180	2100	780		6100	4200	
3	Увс нуурын ДЦГ	120	361	Увс нуурын ай савын УТХГНХЗ	120	35	-	-	67400	5638	1967	891	33872	25032	
4	Хасагт хайрханы ДЦГ	0	0	Монгол элсний УТХГНХЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0	
5	Хөх сэрхийн нурууны ДЦГ	143	276	Хар-Ус нуур орчмын УТХГНХЗ	74	7	31	37	98892	5320	1754	43	37543	54232	
6	Цагаан шувуут уулын ДЦГ	-	-	Увс нуурын ай савын УТХГНХЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	
7	Богдхан уулын ДЦГ	-	-	Богдхан уулын ДЦГ хамгаалалтын захиргаа	-	-	-	-	-	-	-	-	-	-	
8	Ноён уулын ДЦГ-1	8	31	Хан Хэнтийн УТХГНХЗ	8	-	-	38	5684	218	386	-	3200	1580	
9	Ноён уулын ДЦГ-2														
10	Хан Хэнтийн ДЦГ	1	3	Хан Хэнтийн УТХГНХЗ	1	-	-	-	7	45	-	-	-	-	

³¹¹ Энэхүү судалгаанд зөвхөн БОАЖЯ-ны шууд харьяа ТХГН-ууд хамрагдсан.

11	Говийн бага /А/ ДЦГ	46	218	Говийн бага ДЦГ-аарын хамгаалалтын захиргаа	35	27	33	14	33698	465	276	869	15499	16589
12	Говийн бага /Б/ ДЦГ	127	367	Говийн бага ДЦГ-аарын хамгаалалтын захиргаа	83	56	68	73	124896	1268	1358	1387	65214	55669
13	Говийн их /А/ ДЦГ	0	0	ГИДЦГ-ын А хэсгийн хамгаалалтын захиргаа	0	0	0	0	12000	0	120	200	3680	8000
14	Говийн их /Б/ ДЦГ	0	0	Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэг	ДЦГ-ын хязгаар-лалтын бүсэд 42 өвөлжөө хаваржаа байдаг.	ДЦГ-ын хязгаар-лалтын бүсэд 31 өвөлжөө хаваржаа байдаг.	0	0	0	0	0	0	0	0
15	Дорнод Монголын ДЦГ	19	76	Дорнод хамгаалалтын захиргаа	19	19	8	6	8812	2510	1760	90	2593	1859
16	Монгол дагуур /А/-ын ДЦГ	34	136	Дорнод хамгаалалтын захиргаа	34	30		34	28868	1871	2734	89	16108	8066
17	Монгол дагуур /Б/-ийн ДЦГ	110	550	Дорнод хамгаалалтын захиргаа	110	65	34	110	37244	5111	8541	52	15120	9420
18	Нөмрөгийн ДЦГ	Байхгүй	Байхгүй	Нөмрөг ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	0	0	0	0	0	0	0	0	0	0
19	Зэд-Хантай-Бүтээлийн ДЦГ	27	119	Зэд-Хантай-Бүтээлийн нурууны ДЦГ	27	7	-	-	10612	1335	2182	-	3785	3310
20	Отгонтэнгэрийн ДЦГ	1	6	Отгонтэнгэрийн УТХГНХЗ	1	-	-	5	570		40	-	300	230
21	Улаан тайгын ДЦГ	36	142	Улаан тайгын УТХГНХЗ	35	1	-	-	10053	1555	995	0	5080	2423
22	Хорьдол сарьдагийн ДЦГ	Айл байхгүй	0	Улаан тайгын УТХГНХЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР														
23	Алтай таван бог	950	2580	Монгол Алтайн нурууны УТХГ	150	443	100	257	274668	22140	11547	323	134071	106587
24	Ачит нуур Дэвэлийн арал	160	480	Ачит нуур-Дэвэлийн арлын БЦГ-ын хамгаалалтын захиргаа	12	9	10	-	80000	12000	9000	800	32100	27100

25	Булан гол-Их онгог	144	641	Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа	128	141	0	43	30201	3171	1545	265	4737	20440
26	Говь гурван сайхан	223	873	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	169	84	-	-	65737	21	459	5804	6085	53368
27	Горхи-Тэрэлж	334	1123	Горхи-Тэрэлжийн БЦГ захиргаа	239	95	0	0	56764	9505	3690	41	25508	18020
28	Гутайн даваа хөмүүл голын эх	31	74	Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	31	18	26	-	2797	2091	706	-	-	-
29	Дарьганга	367	1308	Дарьгангын БЦГХЗ	189	136	124	102	89471	8424	14893	128	35069	30957
30	Заг Байдрагийн голын эхэн сав	63	258	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	35	26	-	-	21165	4811	2120	0	94120	4822
31	Их Богд уул	402	2139	Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	245	67	-	-	126503	973	2534	2343	16431	104222
32	Их газрын чулуу	110	412	Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	52	58	-	-	60228	1025	1549	365	33615	22137
33	Молцог элс	0	0	Хустай нурууны БЦГ ХЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0
34	Монгол элс	53	106	Монгол элсний УТХГНХЗ	50	51	-	-	24200	2280	720	293	9120	10007
35	Мөнххайрхан	504	2225	Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа	177	454	98	307	122439	11270	5741	846	38743	67530
36	Мянган-Угалзат	521	1853	Мянган-Угалзат БЦГ хамгаалалтын захиргаа	107	70	266	466	176870	10375	11661	1109	58643	93610
37	Ноён хантай	42	211	Хантайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	18	5	-	-	11545	2780	565	0	6100	2100
38	Онон - Балж /А/	272	951	Онон-Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	225	4	0	23	47665	19890	5296	0	12736	9743
39	Онон - Балж /Б/			Онон - Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа										
40	Орхоны хөндий	925	3660	Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	381	97	-	-	302298	6	25981	33655	145170	97386
41	Өндөрхаан уул	9	20	Хан Хэнтийн УТХГХЗ захиргаа	8	2	-	-	6900	980	1100	-	2900	1920
42	Сийлхэмийн нуруу /А/	58	232	Монгол Алтайн нурууны УТХГ	55	55	55	55	78657	7496	3221	219	39976	27763

43	Сийлхэмийн нуруу /Б/	180	420	Монгол Алтайн нурууны УТХГ	150	180	100	450	91558	5365	3523	163	35956	46551
44	Тарагатайн нуруу	52	208	Отгонтэнгэрийн УТХГ-ын ХЗ	41	38	38	18	28,865	4,100	3,432	-	12,203	9,150
45	Тухийн нарс	7	25	ТУЖИЙН НАРСНЫ БАЙГАЛИЙН ЦОЦОЛБОР ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА	7	4	4	4	3878	693	165	0	1570	1450
46	Тэнгис-Шишгэд голын ай сав газар	51	200	Улаан тайгын УТХГ-ын хамгаалалтын захиргаа	45	3	3	5948	1625	531	0	2812	980	2045
47	Тэсийн гол, Булнайн нуруу	306	1028	Хөвсгөлийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа	197	224	487	278	86632	7280	9167	36	44042	26107
48	Улаагчины хар нуур	32	130	Отгонтэнгэрийн УТХГ-ын ХЗ	29	16	16	25	21,748	2,184	1,586	39	11,200	6,739
49	Хан хөхийн нуруу	35	115	Хан Хөхийн нурууны УТХГНХЗ	35	0	0	0	15750	630	770	15	7500	6835
50	Хангайн нуруу	340	1200	Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	151	31	-	-	78290	24259	8570	0	28114	17347
51	Хар ус нуур	1712	7206	Хар-Ус нуур орчмын УТХГН-ийн Хамгаалалтын захиргаа	827	576	250	360	691233	25731	30363	7544	261238	366357
52	Хомын тал	167	498	Хомын талын БЦГ-ын Хамгаалалтын захиргаа	160	150	140	140	77863	3629	6213	1786	28476	37759
53	Хорго - Тэрхийн цагаан нуур	223	847	Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	32	8	-	-	15788	5300	1663	0	6908	1917
54	Хөвсгөл	524	2196	Хөвсгөлийн УТХГНХЗ	331	52	54	142	76,603	28230	6096	2	20369	21906
55	Хөгнө Тарна	196	585	Хөгнө Тарны БЦГ хамгаалалтын захиргаа	114	76	62	137	72863	5856	7399	484	67472	43969
56	Хустайн нуруу	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

57	Хяргас нуур	5	16	Хан Хөхийн нурууны УТХГНХЗ	0	5	0	0	0	3250	105	115	68	1510	1452
58	Цамбагарав уул	329	1765	Хар-Ус нуур орчмын УТХГНХЗ	18	38	74	567		139416	12432	5400	32	54120	67432
59	Чигэртэйн голын ай сав	187	658	Хөх Сэрхийн нурууны УТХГНХЗ	93	186	287	18250		4350	2910	32	7467	3491	-
БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАР															
60	Нагалхаан уулын БНГ	8	32	Горхи-тэрэлжийн БЦГ	8	0	0	0		5084	540	650	0	2970	1410
61	Тосон-Хулстайн БНГ	266	1064	Дорнод хамгаалалтын захиргаа	266	152		266		95429	8191	16342	396	44326	26174
62	Тост тосон бумбын БНГ	197	47415	Тост тосон бумбын нурууны БНГ хамгаалалтын захиргаа	312	373	-	-		47415	1659	927	111	3160	41558
63	Тэсийн голын БНГ	306	1028	Хөвсгөлийн УТХГНХЗ	197	224	487	278		86632	7280	9167	36	44042	26107
64	Угтамын БНГ	38	152	Дорнод хамгаалалтын захиргаа	38	10		38		18828	2615	1333	2	10206	4674
65	Яхь нуурын БНГ	42	167	Дорнод хамгаалалтын захиргаа	42	25		42		39512	3018	5814	452	20773	9475
ДУРСГАЛТ ГАЗАР															
66	Хангал нуур	14	32	Хан Хэнтийн УТХГНХЗ	14	-	-	-		8942	933	161	-	2569	527
67	Биндэрьяа хан уул	32	132	Хан Хэнтийн УТХГНХЗ	24	22	22	21		27800	3800	6000	-	12000	6000

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

